



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 5/15

Дэлгэрхаан сум

О.Болд-Эрдэнэд сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3, Дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сахилгын зөрчил гаргасан тус сургуулийн мэдээллийн технологийн багш (О.Болд-Эрдэнэ)-д үндсэн цалинг нэг сарын хугацаагаар 20%-иар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.
2. Сахилгын шийтгэл ногдуулсан тушаалыг мэдээллийн технологийн багш (О.Болд-Эрдэнэ)-д танилцуулан, гарын үсэг зуруулж баталгаажуулахыг сургалтын менежер (Б.Ариунчимэг)-т даалгасугай.
3. Багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ биелүүлж ажиллахыг мэдээллийн технологийн багш (О.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Ж.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Ш.ЦЭРЭНДУЛАМ